

Дундговь аймгийн Луус сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвшигч Б. Жаргалнямын мөрийн хөтөлбөр

1. Мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг шууд зах зээлд борлуулах малчдын хоршооны үйл ажиллагааг дэмжиж ажиллана.
2. Иргэдийн хурлын болон орон нутгийн засаг захиргааны байгууллагаас шийдвэр гаргахдаа иргэд санал бодлоо чөлөөтэй илэрхийлж, оролцох орчин нөхцлийг бүрдүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана.
3. Отор нүүдлийн асуудлыг сумын ИТХ-ын шийдвэрээр тухай бүрд нь бэлчээрийн даацыг тогтоож, талхлагдахаас сэргийлж тодорхой коридороор гаргаж орон нутгуудаар оторлох боломжоор хангана.
4. “Эрүүл иргэн –Эко бүтээгдэхүүн” хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар хоол хүнсний зохистой хэрэглээг төлөвшүүлж, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх мэдээлэл сургалт сурталчилгааг төсөл хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлнэ
5. Цөлжилтийг сааруулах, элсний нүүдлийг багасгах зорилгоор говийн нөхцөлд ургадаг мод бутлаг ургамлыг тарималжуулсан, байгууллага иргэд, аж ахуйн нэгж, нөхөрлөл, хоршоо, төрийн бус байгууллагыг дэмжих орон нутгийн бодлого гаргаж хэрэгжүүлнэ.
6. Жоншны бичил уурхайн ашиглалтыг Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаадлагыг хангаж, хэвийн явуулах хөдөлмөр хуваарилалт, зохион байгуулалтын зохистой хэлбэрийг иргэдийн оролцоотойгоор шийдвэрлэнэ.
7. Багийн төвүүдийг төрийн үйлчилгээний шилдэг нэгж болгон тохижуулж тогтмол ажиллагаатай болгох.
8. Төрийн албан хаагчдын ажлын хариуцлага, сахилга бат, ажлын үр дүнг сайжруулах мэргэжлийн өндөр ур чадвартай боловсон хүчин бүхий төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх анхаарч ажиллана.
9. Луус суманд тогтмол үйл ажиллагаатай Халуун усны асуудлыг шийдвэрлэнэ.

Мөрийн хөтөлбөр боловсруулсан:



Б.Жаргалням

